



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2006 оны 06 сарын 02 өдөр


Дугаар 103

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам”, Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2006 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн ХЭГ/595 тоот албан бичиг болон 2006 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн ХЭГ/1002 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бямбажав овогтой Батжаргалыг АНУ-ын Денвер хот дахь Колорадогийн их сургуулийн магистрантурт төрийн удирдлагын чиглэлээр, Балжинням овогтой Пүрэвжавыг АНУ-ын Лос-Анжелес хот дахь Калифорнийн улсын их сургуулийн магистрантурт хүний нөөцийн удирдлагын чиглэлээр тус тус 2006-2007 оны хичээлийн жилээс 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.
2. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



Ө.ЭНХТҮВШИН